


ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ЁСНЫ ЦАХИМ ХУУДСАНД 2021 ОНД ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор “Төрийн байгууллагын албан ёсны цахим хуудсанд үнэлгээ хийх аргачлал”-ыг шинэчлэн боловсруулан 14 яам, 21 аймгийн албан ёсны цахим хуудсанд үнэлгээ хийсэн.

Шинэчилсэн аргачлалыг Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтад заасны дагуу дахин боловсруулан, яам, агентлагийг 55, аймаг, дүүргийг 59 шалгуур үзүүлэлттэй боловсруулж, Авлигын эсрэг манлайлал, үйл ажиллагааны ил тод байдал, төсөв санхүүгийн ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, цахим хуудасны үнэлгээ гэх 5 хэсгээс бүрдсэн шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээлэл байршуулсан эсэхийг харгалзан тус бүрт 0-3 оноо, нийт 0-100 оноо өгөх замаар үнэлгээ хийнэ.

Үнэлгээгээр яамдыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хоёр жил дараалан тэргүүлж, Гадаад харилцааны яам хамгийн бага 35.7 оноо авсан.

Яам хийсэн үнэлгээний дүн График 1.



Соёлын яам шинээр байгуулагдаж 2021 онд албан ёсны цахим хуудастай болсон тул энэ жилээс үнэлгээнд хамрагдаж эхэлсэн.

Яам “Авлигын эсрэг манлайлал” График 2.



Авлигын эсрэг манлайлал шалгуурыг энэ жил шинээр нэмж оруулсан ба төрийн байгууллагын Авлигын эсрэг хууль тогтоомжоор ил тод байршуулах мэдээллийг шалгуур болгон оруулсан.

Яам “Үйл ажиллагааны ил тод байдал” График 3.



Тухайн жил төлөвлөн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, сайдын тушаал, шийдвэр, салбарын хэмжээнд боловсруулж байгаа хууль, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөл, тусгай зөвшөөрөлтэй

холбоотой мэдээлэл зэргийг цахим хуудсандаа ил тод байршуулаагүй зөрчил түгээмэл байна.

Яам “Төсөв санхүү, худалдан авах ажиллагаа” График 4.



Тухай жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр холбогдох баримтын хамт шилэн дансанд байршуулаагүй зэрэг зөрчил түгээмэл байна.

Яам “Төсөв санхүү, худалдан авах ажиллагаа” График 5.



Сул орон тооны зар, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт тухай бүр шинэчилж байршуулаагүй, Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх, үнэлгээ өгөх боломжоор хангасан эсэх, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулаагүй зэрэг зөрчил түгээмэл байна.

Яам “Цахим хуудсанд өгөх үнэлгээ” График 6.



Цахим хуудсанд өгөх үнэлгээг иргэд тухайн цахим хуудсаар үйлчлүүлж мэдээлэл авахад энгийн хялбар, ойлгомжтой эсэхэд оноо өгнө. Тухайлбал, Мэдээллийн чанар ойлгомжтой байсан эсэх, хайлтын системтэй, ажиллаж буй эсэхэд үнэлгээ өгдөг.


Яамдын цахим хуудсанд дутуу байршуулсан мэдээлэлтэй танилцахад Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсанд байршуулахгүй байх, Хүний нөөцийн сул орон тооны зар, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг тухай бүр зэрэг зөрчлүүд түгээмэл байна.

Харин 21 аймгийн албан ёсны цахим хуудсанд үнэлгээ хийхэд Дорноговь аймаг хамгийн өндөр оноогоор 90.3 оноогоо үнэлэгдэж, Баян-Өлгий аймаг 41.8 оноогоор дахин хамгийн бага оноо авсан.


Аймгуудын цахим хуудсанд дутуу байршуулсан мэдээлэлтэй танилцахад авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулаагүй байх, төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлээгүй, олгож буй тусгай зөвшөөрөл түүний жагсаалт, иргэд аж ахуйн нэгжээс өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлээгүй, үйлчлүүлэгчээс авч буй төлбөр,

хураамжийн үнэ, тарифын талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл журмын хамт байршуулаагүй, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг олон нийтэд мэдээлээгүй зэрэг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчлүүд түгээмэл байна.

Аймагт хийсэн үнэлгээний дүн 2020-2021 График 7.




Аймаг “Авлигын эсрэг манлайлал” График 8.




Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг ил тод байршуулаагүй зөрчил түгээмэл байна.

Аймаг “Үйл ажиллагааны ил тод байдал” График 9.




Тухайн жил төлөвлөн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, Засаг даргын захирамж, Боловсруулж байгаа хууль Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа ил тод байршуулаагүй зөрчил түгээмэл байна.

Аймаг “Төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал” График 10.



Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл /Бүтэн жил, сар бүр/ жилээр байршуулахгүй байх, санхүүгийн болон худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь байршуулахгүй байх, Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх /СЯ, аймаг, нийслэл, дүүрэг, сум хариуцах/ мэдээллийг байршуулаагүй зөрчил түгээмэл байна. График мэдээллээс харахад баруун бүсийн аймгууд төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг хангалтгүй байршуулсан байна.

Аймаг “Хүний нөөцийн ил тод байдал” График 11.



Сул орон тооны зар, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт тухай бүр шинэчилж байршуулаагүй, Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх, үнэлгээ өгөх боломжоор хангасан эсэх, албан хаагчдын ажлын

гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулаагүй зэрэг зөрчил түгээмэл байна.

Аймаг “Цахим хуудсанд өгөх үнэлгээ” График 11



Энэ жилийн шинэчилсэн аргачлалаар үнэлгээ хийсэн тул яам, аймгийн цахим хуудсанд хийсэн үнэлгээний дүн харилцан адилгүй гарахад нөлөөлсөн. 21 аймгийн хувьд шинэчилсэн аргачлалаар хагас жилийн байдлаар үнэлгээ хийсэн дүнг аймгуудын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт 2021 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар танилцуулсны дараа 2021 оны 12 дугаар сард дахин үнэлэхэд цахим хуудсанд оруулаагүй мэдээллүүдийг шинэчилсэн эерэг, оноо ахисан үр дүн гарсан байна.